



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/065/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.11</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
Завсрын аудитыг 2024.12.17-2024.12.18-ны хооронд хэрэгжүүлсэн ба илэрсэн алдаа зөрчлийг асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжандангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.19 № 2/15

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Аудитаар илэрсэн алдаа нь урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын 7,181.9 мянган төгрөгийн түвшнээс хэтэрсэн.

- Эрүүл мэндийн сайдын 2024.05.28-ны А/241 дугаартай "Тоног төхөөрөмж худалдан авах төсөв баталж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар эрх шилжсэн 30,000 мянган төгрөгийн үнэ бүхий шүдний тоног төхөөрөмж /иж бүрдэл/ худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулан, Дөрвөн Сайхан Мед ХХК-аас 30,000.0 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.3 дугаар заалт "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны 02 дугаар тогтоолын "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар" заалтууд,

5020150

УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт болон Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант оны эцэст Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 208,567.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 15.4 мянган төгрөгийн авлагатай. Эмийн өглөг 18,746.9 мянган төгрөг байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/452-р тушаалаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон салбарын бусад байгууллагуудад 2024 онд үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөөс Галуут сумын Эрүүл мэндийн төвд нийт 23,245.6 мянган төгрөгийн бараа материал шилжүүлснээс 2,895.6 мянган төгрөгийн бараа материалыг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газартай тооцоо нийлэн хүлээн авч 2025 онд орлогод авсан бол үлдсэн 20,350.0 мянган төгрөгийн бараа материал нь тус Эрүүл мэндийн төвд ирээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,611.7 мянган төгрөгийн шатахууныг баримтгүйгээр орлого авч, зарцуулж тайлагнасан зөрчилд тогтоосон төлбөрийн акт төлөгдөөгүй байгаа бөгөөд хуулийн байгууллагад шилжүүлж шалгагдаж байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд нийт 54 ажил төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь 90.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА-ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>87,031,042.20</u>	<u>228,532,263.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,885,067.20	760,500.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,885,067.20	760,500.00
3121	Төгрөг	19,885,067.20	760,500.00
31211	Төрийн сангийн харилцах	19,885,067.20	760,500.00
33	АВЛАГА	19,094,933.00	208,582,717.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	15,425.84
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	19,094,933.00	208,567,291.41
35	БАРАА МАТЕРИАЛ	48,051,042.00	19,189,046.45
351	Түүхий эд материал	3,395,375.00	2,113,854.00
35130	Эм боох материал	3,395,375.00	2,113,854.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	5,000,000.00	5,000,000.00
354	Хангамжийн материал	39,655,667.00	12,075,192.45
35410	Бичиг хэргийн материал	743,500.00	518,500.00
35420	Аж ахуйн материал	38,912,167.00	11,556,692.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,058,025,502.31</u>	<u>1,471,069,895.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,058,025,502.31	1,471,069,895.63
392	Биет хөрөнгө	1,014,567,502.31	1,427,611,895.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	860,578,923.01	1,211,911,487.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-157,423,434.83	-174,501,677.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	62,120,000.00	189,042,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,136,666.74	-15,907,516.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	404,925,351.64	409,285,307.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-189,542,365.05	-246,427,651.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,466,344.00	87,333,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,267,357.16	-39,769,476.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,832,000.00	9,032,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,985,292.56	-2,385,825.88
393	Биет бус хөрөнгө	43,458,000.00	43,458,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	43,458,000.00	43,458,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,145,056,544.51</u>	<u>1,699,602,159.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>682,381.00</u>	<u>18,746,980.65</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	682,381.00	18,746,980.65
413	Өглөг	682,381.00	18,746,980.65
4136	Бусад өглөг	682,381.00	18,746,980.65
41361	Байгууллагад төлөх өглөг	682,381.00	18,746,980.65

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,144,374,163.51</u>	<u>1,680,855,178.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,144,374,163.51	1,680,855,178.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	247,732,382.97	247,732,382.97
51101	Өмч: - төрийн	247,732,382.97	247,732,382.97
512	Хуримтлагдсан үр дүн	245,304,420.59	781,785,435.76
51210	Өмнөх үеийн үр дүн	245,304,420.59	245,304,420.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	536,481,015.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	651,337,359.95	651,337,359.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,145,056,544.51</u>	<u>1,699,602,159.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	886,187,567.00	1,890,450,529.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,878,612.10	585,034,625.08
120	Нийтлэг татварын бус орлого	51,878,612.10	585,034,625.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,878,612.10	39,487,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	39,487,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	834,308,954.90	1,305,415,903.95
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,003,800.00	57,367,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,003,800.00	57,367,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	790,305,154.90	1,248,048,603.95
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	790,305,154.90	1,248,048,603.95
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,014,377,137.14	1,353,969,513.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,377,137.14	1,353,969,513.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,139,459.78	1,351,578,164.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,185,496.92	754,669,585.62
210101	Үндсэн цалин	302,646,069.35	443,544,793.62
210102	Нэмэгдэл	154,041,938.57	251,895,462.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	533,000.00	5,660,000.00
210104	Урамшуулал	58,964,489.00	53,569,330.00

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,228,005.92	94,831,969.93
210201	Тэтгэврийн даатгал	44,592,757.77	64,123,815.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,246,206.70	7,660,317.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,183,765.41	4,394,778.55
210204	Ажилгүйдлийн даатгал	1,034,978.32	3,736,212.36
210205	Эрүүл мэндийн даатгал	10,170,297.72	14,916,846.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,772,102.64	53,475,951.00
210301	Гэрэл, цахилгаан	4,074,278.64	4,308,111.00
210302	Түлш, халаалт	34,444,224.00	49,167,840.00
210303	Цэвэр, бохир ус	1,253,600.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,222,496.06	139,112,212.63
210401	Бичиг хэрэг	4,152,800.00	7,187,750.00
210402	Тээвэр, шатахуун	37,651,620.06	38,281,337.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,054,100.00	2,138,100.00
210404	Ном, хэвлэл	3,500,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	55,137,443.00	44,893,561.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	9,346,200.00
210408	Бараа материал акталсны зардал	17,726,533.00	37,265,264.55
2105	Нормативт зардал	117,179,023.00	150,832,716.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96,587,923.00	125,973,486.00
210502	Хоол, хүнс	19,881,100.00	15,961,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	710,000.00	8,897,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,117,793.00	12,098,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,625,000.00
210602	Тавилга	2,861,293.00	00.00
210604	Урсгал засвар	35,256,500.00	10,473,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,142,000.00	3,800,600.00
210702	Дотоод албан томилолт	2,142,000.00	3,800,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	861,381.96	1,816,579.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	608,742.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	209,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,859.96	37,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	473,000.00
210807	Газрын төлбөр	135,780.00	97,004.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,431,160.28	140,940,550.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,923,005.30	12,117,380.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,508,154.98	128,823,170.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,237,677.36	2,391,349.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,550,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,687,677.36	2,391,349.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,687,677.36	2,391,349.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-128,189,570.14	536,481,015.17
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-128,189,570.14	536,481,015.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	815,284,021.90	1,155,430,545.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	39,487,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	39,487,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	39,487,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	39,487,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	815,214,021.90	1,115,943,545.54
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,003,800.00	57,367,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,003,800.00	57,367,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	771,210,221.90	1,058,576,245.54
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	771,210,221.90	1,058,576,245.54
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	881,564,221.16	1,144,865,112.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,564,221.16	1,144,865,112.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,326,543.80	1,142,473,763.74

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,207,909.05	757,151,369.39
210101	Үндсэн цалин	284,702,142.59	418,050,774.39
210102	Нэмэгдэл	154,300,301.92	270,499,991.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	533,000.00	5,642,959.00
210104	Урамшуулал	79,672,464.54	62,957,645.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,032,596.85	92,365,612.00
210201	Тэтгэврийн даатгал	44,441,185.80	63,086,335.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,234,231.32	7,293,045.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,174,184.49	5,807,492.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,035,482.13	1,593,115.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,147,513.11	14,585,625.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,816,122.64	53,475,951.00
210301	Гэрэл, цахилгаан	4,171,898.64	4,308,111.00
210302	Түлш, халаалт	34,444,224.00	49,167,840.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64751648.00	69198607.00
210401	Бичиг хэрэг	4,055,300.00	7,187,750.00
210402	Тээвэр, шатахуун	35,461,300.00	38,281,057.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,978,100.00	2,138,100.00
210404	Ном, хэвлэл	3,500,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,737,048.00	11,593,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,019,900.00	9,998,200.00
2105	Нормативт зардал	119,496,600.00	132,608,945.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96,611,600.00	111,561,645.35
210502	Хоол, хүнс	19,885,000.00	12,149,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	8,897,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,772,500.00	20,492,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,246,000.00	8,352,000.00
210602	Тавилга	2,785,000.00	00.00
210604	Урсгал засвар	37,741,500.00	12,140,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,142,000.00	3,800,600.00
210702	Дотоод албан томилолт	2,142,000.00	3,800,600.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	861,381.96	1,814,479.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	601,242.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	209,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,359.96	35,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	473,000.00
210807	Газрын төлбөр	135,780.00	97,004.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,245,785.30	11,566,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,245,785.30	11,566,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,237,677.36	2,391,349.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,550,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,687,677.36	2,391,349.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,687,677.36	2,391,349.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-66,280,199.26</u>	<u>10,565,432.80</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,075,100.00	29,690,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,075,100.00	29,690,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,075,100.00	29,690,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,075,100.00	29,690,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-17,075,100.00</u>	<u>-29,690,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-83,355,299.26	-19,124,567.20
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	103,240,366.46	19,885,067.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,885,067.20	760,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	245,304,420.59	1,144,374,163.51
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	245,304,420.59	1,144,374,163.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	245,304,420.59	1,144,374,163.51
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	536,481,015.17	536,481,015.17
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	781,785,435.76	1,680,855,178.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		19,885,067.20		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,254,361,300.00	1,172,058,763.74	82,302,536.26	93.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,254,361,300.00	1,172,058,763.74	82,302,536.26	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,254,361,300.00	1,172,058,763.74	82,302,536.26	93.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	820,861,900.00	757,151,369.39	63,710,530.61	92.2
210101	Үндсэн цалин	421,908,000.00	418,050,774.39	3,857,225.61	99.1
210102	Нэмэгдэл	319,298,200.00	270,499,991.00	48,798,209.00	84.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	5,642,959.00	957,041.00	85.5
210104	Урамшуулал	73,055,700.00	62,957,645.00	10,098,055.00	86.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,608,400.00	92,365,612.00	10,242,788.00	90.0
210201	Тэтгэврийн даатгал	69,680,900.00	63,086,335.00	6,594,565.00	90.5
210202	Тэтгэмжийн даатгал	8,231,900.00	7,293,045.00	938,855.00	88.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,330,200.00	5,807,492.00	522,708.00	91.7

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
210204	Ажилгүйдлийн даатгал	1,901,700.00	1,593,115.00	308,585.00	83.8
210205	Эрүүл мэндийн даатгал	16,463,700.00	14,585,625.00	1,878,075.00	88.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,867,300.00	53,475,951.00	2,391,349.00	95.7
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	4,308,111.00	1,191,889.00	78.3
210302	Түлш, халаалт	49,167,300.00	49,167,840.00	-540.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	00.00	1,200,000.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	70,711,600.00	69,093,607.00	1,617,993.00	97.7
210401	Бичиг хэрэг	7,703,100.00	7,082,750.00	620,350.00	91.9
210402	Тээвэр, шатахуун	39,237,700.00	38,281,057.00	956,643.00	97.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,347,200.00	2,138,100.00	209,100.00	91.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,423,600.00	11,593,500.00	-169,900.00	101.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.00	9,998,200.00	1,800.00	100.0
2105	Нормативт зардал	136,752,200.00	132,608,945.35	4,143,254.65	97.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,110,200.00	111,561,645.35	3,548,554.65	96.9
210502	Хоол, хүнс	12,642,000.00	12,149,800.00	492,200.00	96.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,000,000.00	8,897,500.00	102,500.00	98.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,182,000.00	50,182,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,502,000.00	36,502,000.00	0.00	100.0
210602	Тавилга	1,540,000.00	1,540,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	12,140,000.00	12,140,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,820,000.00	3,800,600.00	19,400.00	99.5
210702	Дотоод албан томилолт	3,820,000.00	3,800,600.00	19,400.00	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,990,800.00	1,814,479.00	176,321.00	91.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	233,600.00	209,475.00	24,125.00	89.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,400.00	35,000.00	3,400.00	91.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	00.00	15,000.00	0.0

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	494,800.00	473,000.00	21,800.00	95.6
210807	Газрын төлбөр	209,000.00	97,004.00	111,996.00	46.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11567100.00	11566200.00	900.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,567,100.00	11,566,200.00	900.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,848,272,950.54	1,155,325,545.54	692,947,405.00	62.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,367,300.00	57,367,300.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	57,367,300.00	57,367,300.00	0.00	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,790,905,650.54	1,058,576,245.54	732,329,405.00	59.1
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,790,905,650.54	1,058,576,245.54	732,329,405.00	59.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА С	00.00	39,382,000.00	-39,382,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	39,382,000.00	-39,382,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,885,067.20	-19,885,067.20	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	760,500.00	-760,500.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	0	100
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	0	100
620003	Үйлчлэх ажилтан	6	6	0	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төв нь сумынхаа хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар, хүртээмжтэй үзүүлэх эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 554,545.6 мянган төгрөг буюу 48.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,031,042.20	228,532,263.70	141,501,221.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,885,067.20	760,500.00	-19,124,567.2
АВЛАГА	19,094,933.00	208,582,717.25	189,487,784.3
БАРАА МАТЕРИАЛ	48,051,042.00	19,189,046.45	-28,861,995.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,058,025,502.31	1,471,069,895.63	413,044,393.3
Хуримтлагдсан элэгдэл	-394,805,116.34	-479,442,148.90	-84,637,032.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,145,056,544.51	1,699,602,159.33	554,545,614.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	682,381.00	18,746,980.65	18,064,599.7
Засгийн газрын хувь оролцоо	1,144,374,163.51	1,680,855,178.68	536,481,015.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,145,056,544.51	1,699,602,159.33	554,545,614.8

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 760.5 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 19,124.5 мянган төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 208,582.2 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага өмнөх оноос 189,472.3 мянган төгрөгөөр өссөн буюу санхүүжилт дутуу орж ирсэн, мөн ажилчидтай холбоотой НДШ-ын 15.4 мянган төгрөгийн илүү төлөлтийг тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,189.0 мянган төгрөг болж 28,861 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал 36,654.4 мянга, бичиг хэрэг 225.0 мянга, эм боох материалын 385.7 мянга буюу нийт 37,266 мянган төгрөгийн бараа материал акталж, данснаас хассан нь голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,471,069.8 мянган төгрөг болж 413,044.3 мянган төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 04-р сарын 03-ны өдрийн 25 дугаар захирамжаар тус эрүүл мэндийн төвийн хуучин Халдвартын эмнэлгийн барилгад их засвар хийн ахмадын амралтын төв болгосон бөгөөд 351,332.5 мянган төгрөгөөр балансын үнэ өсөж дахин капиталжуулсан байна. Мөн Галуут сумын ЭМТ-ын даргын 2024.12.30-ны өдрийн А/51-р тушаалаар төсвийн хөрөнгөөр худалдан авсан 29,690.0 мянга, Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2024.04.19-ны өдрийн А/188-р тушаалаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 160,845.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авсан бол аймгийн ИТХ-ын даргын 2024.05.30-ны 38 дугаар захирамжаар нийт 44,186.1 мянган төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж бүртгэлээс хассан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 18,746.9 мянган төгрөг байгаа нь нийлүүлэгч байгууллагуудад төлөх эмийн төлбөрийн үлдэгдэл бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,680,855.1 мянган төгрөг болж 536,481.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 536,481.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,790,905.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 57,367.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,848,272.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,790,905.5 мянга, орон нутгийн төсвөөс 57,367.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,058,576.2 мянга, орон нутгийн төсвөөс 57,367.3 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 39,392.0 мянга (Үүнд: Завсрын аудитаар барагдуулсан спортын хувцасны актын төлбөр, Эрүүл мэндийн сайдын тушаалаар эрх шилжүүлэн худалдан авсан шүдний тоног төхөөрөмжийн үнэ, эрчүүдийн үзлэгтэй холбоотой санхүүжилт болон өвөлжилт хүндрэлтэй сумдад олгосон шатахууны зардал зэрэг), оны эхний үлдэгдэл 19,885.0 мянга, урсгал үйл ажиллагаанд 1,172.0 мянган төгрөгийг зарцуулж, 2,391.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,172.0 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 93 хувийг зарцуулсан байгаа нь төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос 39,392.0 мянган төгрөг нэмэлтээр бий болгосон нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,254,361,300	1,172,058,764	82,302,536	93
1	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	57,367,300	54,975,951	2,391,349	95.83
2	80302 Нэг иргэнд ногдох нормативаар	831,472,600	806,830,711.24	24,641,889	97.04
3	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	293,751,600	258,367,601.50	35,383,999	87.95
4	83603 Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	71,769,800	51,884,500	19,885,300	72.29

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу харьцуулалтын аргаар түлш шатахуун болон хоол хүнсний цахим худалдан авалт, Эрүүл мэндийн сайдын 2024.05.28-ны А/241 дугаартай "Тоног төхөөрөмж худалдан авах төсөв баталж, эрх шилжүүлэх тухай" тушаалын хүрээнд шүдний тоног төхөөрөмжийн шууд худалдан авалт хийсэн байна.

Тус байгууллага нь 37,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий шатахуун худалдан авах гэрээг НИК ХХК-тай, 37,699.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол хүнс нийлүүлэх гэрээг Үүрд оргих ХХК-тай тус тус байгуулсан нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангасан бол 30,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий шүдний тоног төхөөрөмж худалдан авах гэрээг шууд худалдан авалт хийсэн нь тус хуулийн 10 дугаар зүйл 10.3 дугаар заалт, МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв болох 1,196,994.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,969.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 7,181.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын зардлыг үзэхэд нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 6,622.0 мянган төгрөгийн спортын хувцас худалдан авч тус хуулийн хуулийн 8 дугаар зүйл 8.2 дугаар заалтыг зөрчсөн байсныг завсрын аудитаар акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулсан болно.

Мөн тус Эрүүл мэндийн төвийн цэвэр бохир усны төлбөр 1,253.6 мянган төгрөгөөр буюу 100% хэмнэгдсэн нь цэвэр бохир усны шугам гэмтсэн тул гүний худгаас цэвэр усаа авч байгаатай холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан орлогын 29,630.6 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитыг 2024.12.17-2024.12.18-ны хооронд хэрэгжүүлсэн ба илэрсэн алдаа зөрчлийг асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг Глобал капитал аудит ХХК-ын аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэсэн ба аудитаар тус онд худалдан авсан шатахуун авах зөвшөөрлийн бичгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын e-tax-mta.mn цахим системд шивсэн борлуулалтын и-баримттай тулган шалгахад нийт 10,611.7 мянган төгрөгийн шатахууныг баримтгүйгээр орлого авч, зарцуулснаар тайлагнасан тус төлбөрийн акт төлөгдөөгүй ба хуулийн байгууллагад шилжүүлж шалгагдаж байна.

2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэсэн бөгөөд тус аудитаар 26,226.7 мянган төгрөгийн мөнгөн дүн бүхий 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлсэн ба биелэлт 100 хувь байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/452-р тушаалаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон салбарын бусад байгууллагуудад 2024 онд үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөөс Галуут сумын Эрүүл мэндийн төвд нийт 23,245.6 мянган төгрөгийн бараа материал шилжүүлснээс 2,895.6 мянган төгрөгийн бараа материалыг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газартай тооцоо нийлэн хүлээн авч 2025 онд орлогод авсан бол үлдсэн 20,350.0 мянган төгрөгийн бараа материал нь тус Эрүүл мэндийн төвд ирээгүй байна. Тиймээс ирээгүй хөрөнгийн талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яаманд хийгдэх аудитаар тодруулан үзэх шаардлагатай байна

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65,982.6 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс 6,622.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 59,630.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 30,000.0 мянган төгрөгийн материаллагаар тооцсон залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 22,818.1 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Галуут сумын ЭМТ-ийн даргын ЭНИСЭ ХХК-ийн захирал С.Энхбулгантай 2024.05.28-нд байгуулсан бараа худалдах, худалдан авах гэрээгээр нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 6,622.0 мянган төгрөгийн спортын хувцас худалдан авсан

байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.2 дугаар заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар төлбөрийг бүрэн барагдуулсан болно.

5.2 Албан шаардлага

5.2.1 Эрүүл мэндийн сайдын 2024.05.28-ны А/241 дугаартай "Тоног төхөөрөмж худалдан авах төсөв баталж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар Галуут сумын ЭМТ-д 30,000 мянган төгрөгийн үнэ бүхий шүдний тоног төхөөрөмж /иж бүрдэл/ худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй буюу төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.3 дугаар заалт "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэх, МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 29,630.6 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.5 дахь заалт "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" -ийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд нөхөж мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 6,622.0 мянган төгрөгийн спортын хувцас худалдан авсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.2 дугаар заалтыг зөрчсөн байна.	1	6,622.0	1	6,622.0				
Дүн	1	6,622.0	1	6,622.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш 29,630.6 үнийн дүн бүхий орлогын 4 гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	1	29,630.6			1	29,630.6		
Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил								
Эрүүл мэндийн сайдын 2024.05.28-ны А/241 дугаартай "Тоног төхөөрөмж худалдан авах төсөв баталж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар Галуут сумын ЭМТ-д 30,000 мянган төгрөгийн үнэ бүхий шүдний тоног төхөөрөмж /иж бүрдэл/ худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй буюу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.3 дугаар заалт, МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн байна.	1	30,000.0			1	30,000.0		
Дүн	2	59,630.6			1	59,630.6		

7. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ						1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ						1		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----